НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

2026 IX

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

САРЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 9 дүгээр сар

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2024-2026 он	1
	Чингэлтэй дүүргийн өрх, хүн амын 2025 оны үндсэн үзүүлэлт	2
I	Эрүүл мэнд	4
II	Нийгмийн даатгал, халамж	7
III	Гэмт хэрэг	10
IV	Дүүргийн төсөв	12
V	Хэрэглээний үнэ	15
VI	Нийтийн аж ахуй	18
VII	Аюулгүй байдал	19
VIII	Төрийн бусад үйлчилгээ	20
IX	Аж үйлдвэр	24
X	Хөдөлмөр	27

ХҮСНЭГТ 1. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, оноор

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 IX	2025 IX	2026 IX
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	1 458↓16.3	1 468↑0.7	1 314↓10.5
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	917↓11.1	1 971↑114.9	1 299↓34.1
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)	Хувь	0.4↑0.2	0.1↓0.3	0.4↑0.3
Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	159.0↑27.8	196.0↑23.3	229.1 ↑16.9
Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	161.7↑35.2	189.9↑17.4	229.7↑21.0
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст	1US$ =₮	3 381.2↑8.4	3 591.1↑6.2	3 597.3↑0.2

ХҮСНЭГТ 2. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН 2025 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дүүргийн дүн	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн дундаж ам бүлийн тоо[1]	Хүн ам зүйн ачаалал[2]
	36 782	129 116	3.5	56.1
1 -р хороо	847	3 197	3.8	65.4
2 -р хороо	962	3 177	3.3	64.1
3 -р хороо	1 541	5 405	3.8	62.4
4 -р хороо	1 237	4 874	3.9	57.4
5 -р хороо	1 180	4 441	3.8	58.0
6 -р хороо	2 489	9 084	3.6	63.6
7 -р хороо	1 807	5 984	3.3	52.2
8 -р хороо	863	2 998	3.5	49.8
9 -р хороо	1 489	5 267	3.5	51.0
10 -р хороо	1 981	7 325	3.7	56.9
11 -р хороо	1 176	4 189	3.6	51.2
12 -р хороо	1 529	5 372	3.5	53.4
13 -р хороо	1 743	6 397	3.7	57.1
14 -р хороо	1 559	5 150	3.3	53.5
15 -р хороо	2 060	7 358	3.6	54.6
16 -р хороо	2 030	7 393	3.6	58.0
17 -р хороо	2 161	7 059	3.3	53.9
18 -р хороо	1 570	5 758	3.7	49.2
19 -р хороо	2 061	6 857	3.3	52.3
20-р хороо	1 274	4 268	3.4	53.4
21-р хороо	1 893	6 993	3.7	57.5
22-р хороо	1 184	4 035	3.4	56.0
23 -р хороо	1 218	3 945	3.2	59.5
24 -р хороо	928	2 590	3.8	60.5

[1] Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо

[2] Нэг километр квадрат газар нутагт ногдох хүний тоо

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
* урьдчилсан гүйцэтгэл
** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.
/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.
/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	$=10^6$
тэрум	$=10^9$
их аяд	$=10^{12}$
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
$м^2$	метр квадрат
$дм^2$	дециметр квадрат
$км^2$	километр квадрат
$м^3$	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори($=10^9$ калори)
с	секунд
мин	минут
$мкг/м^3$	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас

МЭДЭЭЛЭЛ

МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

ЭРҮҮЛ МЭНД

I-IX/2026

Тархаасан: 2026 оны 10 дугаар сарын 15

2026 оны эхний 9 сард 1306 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 154 (10.5%) төрөлтөөр буурсан байна.

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2026 оны эхний 9 сард 1306 эх амаржиж, 1314 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх, мэндэлсэн хүүхэд тус бүр 154 (10.5%) буурсан байна.

ХҮСНЭГТ 3. ТӨРСӨН ЭХ, ХҮҮХЭД, ЭНДЭГДЭЛ, 2026 оны эхний 9 сард

Үзүүлэлт	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	Өсөлт, бууралт 2025-2026	
				Тоо	Хувь
Амаржсан эхийн тоо	1 439	1 460	1 306	-154	-10.5
Амьд төрсөн хүүхэд	1 458	1 468	1 314	-154	-10.5
Нас барсан хүн	630	650	613	-37	-5.7
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	15	17	18	1	5.9
1-5 настай хүүхдийн эндэгдэл	5	4	1	-3	-75.0
Амьгүй төрөлт	10	8	8	0	0.0
Гэрийн төрөлт	7	3	4	1	33.3
Хяналтгүй төрөлт	14	8	8	0	0.0

** Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл*

ЗУРАГ 1. АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, сараар



2026 оны эхний 9 сард нийт 676708 удаа эмчийн үзлэг хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26164 (4.0%), эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 4967 болж өмнө оны мөн үетэй харьцуулахад 623 (14.3%) хүнээр тус тус өсжээ.

ЗУРАГ 2. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар



Бэлгийн замын халдварт өвчин 146 буюу нийт халдварт өвчний 11.2 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 4. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, 2026 оны эхний 9 сарын байдлаар

Төрөл	2024 I-IX		2025 I-IX		2026 I-IX		2026/2025	
	Бодит тоо	10000 хүнд ногдох	Бодит тоо	10000 хүнд ногдох	Бодит тоо	10000 хүнд ногдох	Дүн	Хувь
Дүүргийн дүн	**917**	**65.3**	**1971**	**146.4**	**1299**	**99.1**	**-672**	**-34.1**
Гепатит	6	0.4	9	0.7	6	0.5	-3	-33.3
Цусан суулга	121	8.6	62	4.6	56	4.3	-6	-9.7
Сальмоненнез	27	1.9	23	1.7	20	1.5	-3	-13.0
Хоолны хордлого	38	2.7	28	2.1	22	1.7	-6	-21.4
Менингококкт	0	0.0	3	0.2	0.0	0.0	-3	-
Салхин цэцэг	266	19.0	395	29.3	219	16.7	-176	-44.6
Гахайн хавдар	15	1.1	4	0.3	6	0.5	2	50.0
Улаан эсэргэнэ	23	1.6	39	2.9	36	2.8	-3	-7.7
Ёлом	7	0.5	9	0.7	9	0.7	0	0.0
Бруцеллёз	0	0.0	0	0.0	0	0.0	0	-
Гар, хөл, ам	78	5.6	58	4.3	466	35.6	408	8**
B34.1 Энтеровируст халдвар тодорхойгүй	0	0.0	86	6.4	57	4.3	-29	-33.7
Хачигт риккетсиоз	1	0.1	0	0.0	0	0.0	0	-
Эритема	0	0.0	118	8.8	26	2.0	-92	-78.0
Ковид-19	0	0.0	0	0.0	0	0.0	0	-
Улаан бурхан	0	0.0	712	52.9	101	7.7	-611	-85.8
Халдварын гаралтай суулга	4	0.3	7	0.5	0	0.0	-7	-
Бусад	0	0.0	88	6.5	45	3.4	-43	-48.9
Тэмбүү	108	7.7	102	7.6	66	5.0	-36	-35.3
Төрөлхийн тэмбүү	0	0.0	0	0.0	0	0.0	0	-
Заг хүйтэн	34	2.4	47	3.5	15	1.1	-32	-68.1
Сүрьеэ	96	6.8	101	7.5	84	6.4	-17	-16.8
Мөөгөнцөр	16	1.1	18	1.3	15	1.1	-3	-16.7
Трихомониаз	77	5.5	62	4.6	50	3.8	-12	-19.4
ХДХВ/ДОХ	0	0.0	0	0.0	0	0	0	-

** Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл*

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

I-IX/2026 Тархаасан: 2026 оны 10 дугаар сарын 15

Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 9 сард 600.0 тэрбум төгрөгт хүрлээ.

Сангийн төрлөөр авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 51.3 (11.8%) тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 5.7 (12.2%) тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 5.9 (16.6%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 2.2 (12.3%) тэрбум төгрөгөөр тус өссөн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сангийн төрлөөр



ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



Тэтгэврийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 24.4 (12.3%) тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 3.7 (30.9%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 0.2 (20.3%) тэрбум төгрөгөөр өссөн бол ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 1.9 (30.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн сангаас 2026 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 101995 хүнд 80.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 2615 (2.5%) буурч, олгосон тэтгэмж 2.2 (2.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР

Үйлчилгээний төрөл	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд		Өөрчлөлт		Олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн дүн / сая төгрөг/		Өөрчлөлт	
	2025 I-IX	2026 I-IX	Тоо	Хувь	2025 I-IX	2026 I-IX	Тоо	Хувь
Нийт	104 610	101 995	-2 615	-2.5	78 006.2	80 234.7	2 228.5	2.9
Нийгмийн халамжийн тэтгэвэрт	2 546	2 671	125	4.9	8 580.0	10 146.4	1 566.4	18.3
Нийгмийн халамжийн тэтгэмж	71 081	70 095	-986	-1.4	55 249.3	54 524.2	-725.2	-1.3
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	58 003	56 832	-1 171	-2.0	50 349.3	49 132.4	-1 216.9	-2.4
Асаргааны тэтгэмж	3 315	3 503	188	5.7	7 645.7	8 785.6	1 139.9	14.9
Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох	15 371	16 056	685	4.5	2 850.0	3 160.6	310.6	10.9
Алдар цолтон ахмад настанд төрөөс олгох тусламж, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, тэтгэмж	872	991	119	13.6	316.6	674.8	358.2	113.2
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	3 159	1 324	-1 835	-58.1	332.6	132.9	- 199.7	-60.0
Эх, олон хүүхэдтэй ерх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж	8 266	7355	-911	-11.0	3 032.0	2 810.2	- 221.8	-7.3
Жирэмсэн эхийн тэтгэмж	1 941	1 584	-357	-18.3	240.1	194.3	-45.8	-19.1

Нийгмийн халамжийн тэтгэмжид 70095 хүн хамрагдаж, 54.5 тэрбум төгрөг олгосон бөгөөд үүнээс хүүхдийн мөнгөн тэтгэмжид 56832 хүүхдэд 49.1 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 1171 (2.0%) хүүхдээр, олгосон дүн 1.2 (2.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Түүнчлэн эх, олон хүүхэдтэй ерх толгойлсон эцэг, эхэд олгох тэтгэмжид 7355 хүнд 2.8 тэрбум төгрөг олгосон бөгөөд үүнээс жирэмсэн эхийн тэтгэмжид 1584 хүнд 194.3 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 357 (18.3%) хүнээр, олгосон дүн 45.8 (19.0%) сая төгрөгөөр буурсан байна. 2026 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 1306 эх амаржсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 154 (10.5%) эхээр буурсан байна. Энэ нь жирэмсэн эх болон хүүхдийн мөнгөн тэтгэмж буурахад нөлөөлсөн.

Мөн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 1324 хүнд 132.9 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1835 (58.1%) хүнээр, олгосон дүн 199.6 (60.0%) сая төгрөгөөр буурсан нь Гэр бүл, Хөдөлмөр, Нийгэм хамгааллын сайдын А/186 тушаалын дагуу 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах босго оноог шинэчлэн тогтоосонтой холбоотой.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

ГЭМТ ХЭРЭГ

I-IX/2026

Тархаасан: 2026 оны 10 дугаар сарын 15

Дүүргийн хэмжээнд нийт 2944 гэмт хэрэг бүртгэгдсэн өнгөрсөн жилийн мөн үеэс 6.2 хувиар буурсан байна.

2026 оны эхний 9 сард 2944 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 194 (6.2%) хэргээр буурсан үзүүлэлтэй байна. Гэмт хэргийн улмаас 63.6 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 20.5 тэрбум төгрөгөөр буюу 47.5 хувиар өссөн байна. Харин уг хохирлоос 18.5 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлсэн нь нийт хохирлын 29.1 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 37.5 хувийг залилан, 18.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 18.0 хувийг хулгайн, 1.3 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 5.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 0.2 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 2.0 хувийг дээрэм, 1.2 хувийг хүчин, 15.1 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, эхний 9 сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	Тоо	Хувь
Дүүргийн дүн	**2 378**	**3 138**	**2 944**	**-194**	**-6.2**
Хүний амь	3	3	5	2	66.7
Хүчин	34	33	35	2	6.1
Дээрэм	29	57	60	3	5.3
Хулгай	444	407	529	122	30.0
Залилан	950	1 434	1 105	-329	-22.9
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	471	434	533	99	22.8
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	106	139	150	11	7.9
Бусдыг амиа хорлоход хүргэх	13	47	43	-4	-8.5
Бусдын хөрөнгө ашиглах	24	31	39	8	25.8
Бусад гэмт хэрэг	304	553	445	-108	-19.5

ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өөрчлөлт	
	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	**20 563**	**26 679**	**28 594**	**1915**	**7.2**
Багануур	226	281	300	19	6.8
Багахангай	14	25	22	-3	-12.0
Баянгол	3 640	4 273	5 344	1071	25.1
Баянзүрх	6 692	6 890	6 740	-150	-2.2
Налайх	257	222	446	224	100.9
Сонгинохайрхан	2 824	3 512	4 480	968	27.6
Сүхбаатар	3 389	3 846	4 163	317	8.2
Хан-Уул	3 521	4 492	4 155	-337	-7.5
Чингэлтэй	2 378	3 138	2 944	-194	-6.2

2026 оны эхний 9 сарын байдлаар нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэрэг 28594 болж, өмнөх оны мөн үеэс 1915 хэргээр буюу 7.2 хувиар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

ДҮҮРГИЙН ТӨСӨВ

I-IX/2026 Тархаасан: 2026 оны 10 дугаар сарын 15

Дүүргийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 21.0 хувиар өслөө.

Дүүргийн төсвийн нийт орлого 2026 оны эхний 9 сарын байдлаар 229.1 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 30.5 (11.8%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна. Төсвийн нийт орлогын 99.6 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 0.4 хувийг татварын бус орлого эзэлж байна. Дүүргийн татварын орлого 221.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 32.3 (12.7%) тэрбум төгрөгөөр, дутуу, татварын бус орлого 6.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.8 (37.3%) тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн байна.

ЗУРАГ 6. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА



ХҮСНЭГТ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	Төлөвлөгөө (сая төгрөг)	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	**259 569.8**	**229 058.0**	**-30 511.8**	**-11.8**
А. Урсгал орлого	258 658.8	228 161.7	-30 497.1	-11.8
1. Татварын орлого	253 930.3	221 669.4	-32 260.9	-12.7
1.1. Орлогын албан татвар	224 879.2	198 843.2	-26 036.0	-11.6
1.2. Өмчийн татвар	4 687.2	4 637.3	- 49.9	-1.1
1.3. Бусад татвар (төлбөр хураамж)	24 363.9	18 188.8	-6 175.0	-25.3
2. Татварын бус орлого	4 728.6	6 492.4	1 763.8	37.3
Б. Хөрөнгийн орлого	-	-	-	-
В. Тусламжийн орлого	911.0	896.3	-14.7	-1.6

**Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс*

ЗУРАГ 7. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО



ХҮСНЭГТ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2026 оны эхний 9 сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	сая төгрөг			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	**238 493.2**	**229 668.8**	**-8 824.3**	**-3.7**
А. Урсгал зарлага	208 227.6	199 403.2	-8 824.3	-4.2
1. Бараа, үйлчилгээний зардал	66 918.6	58 094.3	-8 824.3	-13.2
1.1. Цалин, хөлс	13 434.0	13 434.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1 547.0	1 547.0	0.0	0.0
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	51 937.6	43 113.3	-8 824.3	-17.0
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	141 308.9	141 308.9	-	-
3.1. Татаас	-	-	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	141 308.9	141 308.9	-	-
Б. Хөрөнгийн зардал	30 265.6	30 265.6	-	-
Хөрөнгө оруулалт	30 265.6	30 265.6	-	-

2026 оны эхний 9 сарын байдлаар дүүргийн төсвийн нийт зарлага 229.7 тэрбум төгрөгт хүрсэн нь төлөвлөсөн зарлагаас 8.8 тэрбум төгрөгөөр буюу 3.7 хувиар бага байна. Нийт зарлагын дийлэнх хэсгийг урсгал зардал бүрдүүлж байгаа бөгөөд 199.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөснөөс 8.8 тэрбум төгрөгөөр буюу 4.2 хувиар бага байна. Харин хөрөнгийн зардал 30.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнд бүрэн зарцуулагдсан байна

ЗУРАГ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА,гүйцэтгэлээр



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

I-IX/2026 Тархаасан: 2026 оны 10 дугаар сарын 15

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өслөө.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2026 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 11.9 хувь, өмнөх сараас 0.4 хувиар өссөн байна.

ЗУРАГ 9. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар



Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2026 оны 9 дүгээр сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 10.4 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 16.7 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 11.4 хувь,

Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 6.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 5.9 хувь, тээвэр 9.2 хувь, боловсролын үйлчилгээ 18.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 18.0 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээ 23.8 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2026 IX / 2025 IX	2026 IX / 2025 XII	2026 IX / 2026 VIII
Ерөнхий индекс	**11.9**	**10.4**	**0.4**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	19.8	16.7	-1.4
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	15.5	11.4	1.9
Хувцас, бөс бараа, гутал	5.8	2.8	0.3
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	6.4	5.9	0.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	7.5	6.5	0.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.2	5.9	0.3
Тээвэр	8.6	9.2	3.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	1.4	1.3	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	7.6	5.0	0.0
Боловсролын үйлчилгээ	18.6	18.6	0.4
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	18.7	18.0	2.5
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	23.8	23.8	0.0
Бусад бараа, үйлчилгээ	9.6	4.4	1.2

ЗУРАГ 10. ГУРИЛ, ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 сард, төгрөг



ЗУРАГ 11. ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 сард, төгрөг

ЗУРАГ 12. ТӨМС, ЛУУВАНГИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 сард, төгрөг



ЗУРАГ 13. ТАРАГ, СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 сард, төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томьёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^{L} = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}}\right)\left(\frac{P_{it-1}}{P_{it-2}}\right)\ldots\left(\frac{P_{i2}}{P_{i1}}\right)\left(\frac{P_{i1}}{P_{i0}}\right)\frac{P_{i0}Q_{i0}}{\sum P_{i0}Q_{i0}}$$

I_{ct}^{L} – t тайлант үеийн Ласдейресийн үнийн индекс
t – Тайлант үе
0 – суурь үе
P_t^i – і барааны тайлант үеийн үнэ
P_0^i – і барааны тайлант үеийн үнэ
q_0^i – і барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигла

НИЙТИЙН АЖ АХУЙ

I-IX/2026

Тархаасан: 2026 оны 10 дугаар сарын 15

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2908.5 мян.м² зам талбай цэвэрлэж, 19464.0 тн хог тээвэрлэжээ.

Тээвэрлэсэн хог 2026 оны 9 дүгээр сард 19464.0 болж, өмнөх жилийн мөн үеэс 6550.1 тн (25.2%) буурсан байна. Ажил үйлчилгээний орлого 2237.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 121.2 (5.1%) сая төгрөгөөр буурчээ. Орлогын эх үүсвэрийг ангилбал 37.8 хувийг гэр хороолол, 59.3 хувийг зам талбай, 2.3 хувийг орон сууц, 0.6 хувийг албан газрын цэвэрлэгээ үйлчилгээнээс олсон орлого тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 11. ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО 2026 оны 9 сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 IX	2025 IX	2026 IX	2025/2026	
					Дүн	Хувь
Цэвэрлэсэн талбай	мян.м^2	2 908.5	2 908.5	2 908.5	-	-
Тээвэрлэсэн хог	Тн	26 369.0	26 014.1	19 464.0	-6 550.1	-25.2
Орон сууц	Тн	-	-	-	-	-
Гэр хороолол	тн	23 076.6	23 154.1	18 073.0	-5 081.1	-21.9
Албан газар	тн	3 292.4	2 860.0	1 391.0	-1 469.0	-51.4
Зам талбай	Тн	.0	.0	.0	-	-
Ажил үйлчилгээний орлого	сая.төг	1 446.5	2 359.0	2 237.8	-121.2	-5.1
Зам талбай	сая.төг	213.2	1 142.2	1 326.9	184.7	16.2
Гэр хороолол	сая.төг	1 079.6	1 083.4	845.8	-237.6	-21.9
Орон сууц	сая.төг	131.0	99.0	52.0	-47.0	-47.4
Албан газар	сая.төг	22.6	34.4	13.1	-21.3	-62.0

**Эх үүсвэр: Найши ХХК, ТҮК*

ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

I-IX/2026

Тархаасан: 2026 оны 10 дугаар сарын 15

Дүүргийн хэмжээнд нийт 34.7 мянган зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19.3 мянган (35.8%) зөрчилөөр буурсан байна.

Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид 2026 оны эхний 9 дүгээр сард гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт 34728 зөрчил илрүүлсэн. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 929 холбогдогчийг шүүхээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийлгэснээс 935 иргэнийг 1 жил тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 267 хүнд торгож, баривчлах шийтгэл оногдуулсан байна

ХҮСНЭГТ 12. ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ

Торгууль	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX
Торгуулсан хүний тоо	66 626	54 071	34 728
Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/	1 198.7	1 575.5	790.8

ХҮСНЭГТ 13. ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр

Зөрчлийн хэлбэр	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX
НИЙТ ЗӨРЧИЛ	66 626	54 071	34 728
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон	1 348	873	929
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон	591	922	935
Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	4 675	4 433	4 601
Хамгаалах бүс хэрэглээгүй	10 237	7 314	4 025
Хориглосон нөхцөлөөр зогссон	9 742	4 871	276
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	15	21	54
Эгнээ байраа буруу эзэлсэн	1 471	1 987	1 499
Бусад зөрчил	38 547	33 650	22 409

**Эх үүсвэр: ЧД-ийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэс*

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 56 буюу 6.4 хувиар буурсан бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй боловч жолоодсон зөрчил 13 буюу 1.4 хувиар өссөн байна.

ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

I-IX/2026 Тархаасан: 2026 оны 10 дугаар сарын 15

2026 оны эхний 9 сард иргэний бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээг 64211 удаа иргэдэд үзүүлсэн байна.

ХҮСНЭГТ 14. ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, үйлчилгээний төрлөөр

Үзүүлэлт	2025 I-IX	2026 I-IX	2025/2026	
	Дүнгээр		Дүн	Хувь
Нийт	**71 709**	**64 211**	**- 7 498**	**-10.5**
Шинэ төрсөн	1 813	1 700	- 113	-6.2
Гэрлэлт	458	379	- 79	-17.2
Гэр бүл цуцлалт	252	204	- 48	-19.0
Хүүхэд үрчлэлт	33	22	- 11	-33.3
Эцэг тогтоосон	82	39	- 43	-52.4
Овог, нэр өөрчлөх	97	97	-	-
Шилжин ирсэн	4 828	4 860	32	0.7
Лавлагаа	42 084	39 340	- 2 744	-6.5
Иргэний үнэмлэх олголт:	11 031	8 785	- 2 246	-20.4
16 нас хүрч шинээр авсан	2 711	2 347	- 364	-13.4
Дахин олголт	8 320	6 438	- 1 882	-22.6

** Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс*

Онцгой байдал:

Аюулт үзэгдэл, ослын дуудлага 2026 оны эхний 9 сард 367 удаа бүртгэгдэж, өмнөх оноос 61 (14.3%)-аар буурсан байна. Тохиолдсон аюулт үзэгдэл, ахуйн 263 гал түймэр гарч, өмнөх оны мөн үеэс 59 (18.3%)-аар буурсан бөгөөд гал түймрийн аюулаас 812 хүн, 205.7 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг аварсан байна.

ХҮСНЭГТ 15. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлтүүд	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Дуудлагын тоо	308	428	367	-61	-14.3
Худал дуудлага	35	22	12	-10	-45.5
Гал түймрийн тохиолдлын тоо	232	322	263	-59	-18.3
Унтраасан гал түймрийн тоо	180	307	229	- 78	-25.4
Ашигласан ус, тонн	787.8	972.9	451.7	-521.2	-53.6
Ашигласан шатахуун /дизель/, литр	5 909.8	7 933.8	4 700.5	-3 233.3	-40.8
Ашигласан хөөс, литр	150.0	2 458.0	100.0	-2 358.0	-95.9
Зарцуулсан хөрөнгө, сая.төг	23.6	28.0	17.7	-10.3	-36.6
Аварсан хүний тоо	326	1 079	812	-267	-24.7
Учирсан хохирол, сая.төг	36 565.5	130 118.2	205 650.0	75 531.8	58.0

[1]-дахин их * *Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтсийн галын мэдээ*

ЗУРАГ 14. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 9 сард

Улаан загалмай: 2026 оны эхний 9 сард 16581 хүнд 32500 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь хамрагдсан хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 4789 (22.4%) хүнээр буурсан бол, зарцуулсан зардал 4720 (17.0%) мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 16. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, төрлөөр эхний 9 сард

Үзүүлэлт	2025 I-IX			2026 I-IX		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/
Дүн	423	21 370	27 780	382	16 581	32 500
Халамж үйлчилгээ	35	1 008	2 500	74	559	8 200
Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа	69	2 197	4 400	25	315	3 100
Анхны тусламжийн сургалт	25	750	1 450	54	1 186	2 600
Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа	29	1 208	2 340	15	888	3 270
Гамшгийн тусламж	2	10	600	-	-	-
Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа	60	5 477	5 890	43	4 077	5 030
Донорын өдөрлөг, сурталчилгаа	52	2 594	600	15	1 560	400
Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа	37	2 295	5 200	42	2 937	5 300
Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа	114	5 831	4 800	114	5 059	4 600

**Эх үүсвэр: Улаан загалмайн хороо*

Захиргааны мэдээлэл: Иргэдээс 2026 оны эхний 9 сард 3214 өргөдөл, гомдол ирсэн нь өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 17. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, эхний 9 сард

Ангилал	2025 I-IX	2026 I-IX	Үүнээс:	
			Шийдвэрлэх шатандаа байгаа	Шийдвэрлэж хариу өгсөн
Нийт	**3 107**	**3 214**	**799**	**2 415**
Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв	29	15	2	13
Нутгийн захиргааны байгууллагууд	1 715	1 646	389	1 256
1800-1200 дугаарын оператор	163	179	47	132
11-11 төвөөс ирсэн	1 158	1 203	303	900
Гар утасны аппликэйшнээр ирсэн				
Мессеж				
E-Service	31	139	48	91
Facebook		5		5
Дижитал сити	5	20	6	14
Хороо бүртгэсэн	4	7	3	4
Smartcar3.0		-	-	-
НМХГ тусгай дугаар	-	1	1	-

АЖ ҮЙЛДВЭР

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 10 дугаар сарын 15

Дүүргийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өслөө.

Дүүргийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 9 дүгээр сарын урьдчилсан 436.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 228.0 (2.1 дахин) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд: уул уурхайн олборлолт 222.2 (3.3 дахин) тэрбум төгрөгөөр, боловсруулах үйлдвэрлэл 9.7 (9.1%) тэрбум төгрөгөөр өссөн, ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 3.9 (44.7%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 18. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

Салбар	Нийт үйлдвэрлэлт			2026* IX / 2025 IX
	2024 I-IX	2025 I-IX	2026* I-IX	
	сая төгрөг			Хувь
БҮГД	**218 780.2**	**208 154.0**	**436 200.2**	**2.1****
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	**58 954.2**	**91 305.8**	**313 479.7**	**3.4****
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	1 172.8	772.3	721.8	- 6.5
Металлын хүдэр олборлолт	34 503.3	83 787.1	278 554.9	3.3**
Бусад ашигт малтмал олборлолт	142.2	0.0	0.0	-
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	23 135.9	6 746.4	34 203.0	5.1**
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	**152 143.6**	**108 100.5**	**117 884.4**	**9.1**
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	8 603.5	32 085.8	12 332.0	- 61.6
Мах боловсруулах, консервлох	4 175.0	26 949.0	142.5	- 99.5
Ундаа үйлдвэрлэл	4 428.5	5 136.8	12 189.6	2.4**
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	114 657.6	46 976.1	74 972.0	59.6
Хувцас үйлдвэрлэл	8 471.4	11 698.1	16 700.4	42.8
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	201.6	208.9	0.0	- 100.0
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11 535.3	10 915.5	4 958.6	- 54.6
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	3 975.8	3 212.7	3 573.0	11.2
Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	2 664.6	2 321.3	5 207.1	2.2**
Тавилга үйлдвэрлэл	1 691.9	64.6	0.0	-
Бусад боловсруулах үйлдвэрлэл	342.1	617.5	141.4	- 77.1
УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	**7 682.3**	**8 747.7**	**4 836.1**	**- 44.7**
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	7 682.3	8 747.7	4 836.1	- 44.7

** - дахин их

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 313.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 222.2 (3.3 дахин) тэрбум төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолт 194.8 (3.3 дахин) тэрбум төгрөгөөр, уул уурхайн туслах үйл ажиллагаа 27.5 (5.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 9 дүгээр сарын

урьдчилсан гүйцэтгэлээр 117.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.7 (9.1%) тэрбум төгрөгөөр өсөхөд ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл 27.9 (59.6%) тэрбум төгрөгөөр, хувцас үйлдвэрлэл 5.0 (42.8%) тэрбум төгрөгөөр, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл 2.8 (2.2дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 2026 оны 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 4.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 (44.7%) тэрбум төгрөгөөр буурахад хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах, дахин ашиглах 3.9 (44.7%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Дүүргийн аж үйлдвэрийн салбар 2026 оны 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 49.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 54.8 хувийг, боловсруулах аж үйлдвэрлэл 43.8 хувийг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 1.4 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, жил бүрийн эхний 9 сард





Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2026 оны 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 420.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 189.4 (1.8 дахин) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд: уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 223.0 (3.4 дахин) тэрбум төгрөгөөр өссөн бол боловсруулах үйлдвэрлэл 30.1 (76.9%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа салбарын борлуулалт 3.4 (60.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Гадаад зах зээлд 2026 оны 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 54.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 54.1 тэрбум төгрөг нь боловсруулах үйлдвэрийн салбарын борлуулалт байна.

ХҮСНЭГТ 19. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

Салбар	Нийт борлуулалт			2026* IX / 2025 IX	Экспорт
	2024 I-IX	2025 I-IX	2026* I-IX		
	сая төгрөг			Хувь	
БҮГД	**221 308.7**	**230 841.4**	**420 286.7**	**1.8****	**12.9**
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	**59 372.3**	**91 574.0**	**314 595.5**	**3.4****	**0.0**
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	1 533.6	1 040.5	759.9	-27.0	0.0
Металлын хүдэр олборлолт	34 519.6	83 787.1	278 554.9	3.3**	0.0
Бусад ашигт малтмал олборлолт	183.1	0.0	1 077.7	-	0.0
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	23 135.9	6 746.4	34 203.0	5.1**	0.0
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	**154 254.1**	**130 519.6**	**100 371.5**	**-23.1**	**53.9**
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	10 620.1	38 000.4	12 173.9	-68.0	1.2
Мах боловсруулах, консервлох	6 179.5	27 071.5	142.5	-99.5	100.0
Ундаа үйлдвэрлэл	4 440.6	10 928.9	12 031.4	10.1	0.0

Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	115 437.2	63 074.3	57 572.5	-8.7	91.9
Хувцас үйлдвэрлэл	8 063.9	12 077.3	16 523.1	36.8	6.4
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	281.2	240.7	0.0	0.0	-
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11 535.3	10 915.5	4 958.6	-54.6	0.0
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	3 986.7	3 243.9	3 780.9	16.6	0.0
Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	2 376.0	2 285.7	5 207.1	2.2**	0.0
Тавилга үйлдвэрлэл	1 611.6	64.6	0.0	0.0	-
Бусад боловсруулах үйлдвэрлэл	342.1	617.5	155.5	-74.8	0.0
УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	**7 682.3**	**8 747.7**	**5 319.7**	**-39.2**	**-**
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	7 682.3	8 747.7	5 319.7	-39.2	-

ЗУРАГ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, жилийн бүрийн эхний 9 сард



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

I-IX/2026 Тархаасан: 2026 оны 10 дугаар сарын 15

Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст ажил хайж бүртгүүлсэн нийт 849 иргэн байна.

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэдийн тоо 2026 оны эхний 9 сард 849 иргэн бүртгэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 510 (60.1) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 17. ДҮҮРГИЙН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр



Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 45 (5.3%) нь 15-24 насны, 150 (17.7%) нь 25-34 насны, 260 (30.6%) нь 35-44 насны, 252 (29.7%) нь 45-54 насны, 142 (16.7%) 55-аас дээш насны хүмүүс байна.

ЗУРАГ 18. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшинээр эхний 9 сарын байдлаар



БҮЛЭГ

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он	
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	Э.Анар
I	Эрүүл мэнд	Б.Мишээлт
II	Нийгмийн даатгал, халамж	Н.Халиун
III	Гэмт хэрэг	Э.Анар
IV	Төсөв	Э.Анар
V	Хэрэглээний үнэ	Л. Шинэтуяа
VI	Нийтийн аж ахуй	Л. Шинэтуяа
VII	Дүүргийн аюулгүй байдал	Э.Анар
VIII	Төрийн үйлчилгээ	Б. Мишээлт Л. Шинэтуяа
IX	Аж үйлдвэр	Н.Халиун
X	Хөдөлмөр	Э.Анар

Танилцуулга хянасан хэлтсийн дарга: ..... Д.МӨНХЗУЛ

Танилцуулга нэгтгэсэн мэргэжилтэн: .....Б.МИШЭЭЛТ

Авлигатай
тэмцэх газар

Хэрэв танд:

-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл;

-Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-ийн шинжтэй гомдол мэдээлэл өгөхөөр бол Авлигатай тэмцэх газарт хандана уу:

Үүнд:

22.1 дүгээр зүйл /*Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах*/;
22.3 дугаар зүйл /*Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах*/;
22.4 дүгээр зүйл /*Нийтийн албан тушаалтан хахууль авах*/;
22.5 дугаар зүйл /*Хахууль өгөх*/;
22.6 дугаар зүйл /*Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах*/;
22.7 дугаар зүйл /*Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх*/;
22.8 дугаар зүйл /*Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах*/;
22.9 дүгээр зүйл /*Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах*/;
22.10 дугаар зүйл /*Үндэслэлгүйгээр хөрөнгөжих*/;
22.11 дүгээр зүйл /*Дураараа ашлах*/;
22.12 дугаар зүйл /*Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах*/;
22.13 дугаар зүйл /*Хахууль авах*/.

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО /ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ/

110
Авлигыг мэдээлэх утас

өргөдөл, гомдол, мэдээлэл
Хүлээн авах суваг

Авлигатай тэмцэх газарт ирж биечлэн
Утсаар: (976)-110 /Ярианы төлбөргүй/
дугаараар
Факс: (976)-11-311919
Цахим шуудангийн хаяг: contact@iaac.mn
Шуудан холбоогоор: Улаанбаатар хот 14250, Сүхбаатар дүүрэг, 5 хороолол, Сөүлийн гудамж 41 хаягаар
Веб сайт: iaac.mn

Авлигын эсрэг
НЭГДЭЕ
Үгүй гэж хэлээд өөрчилье! 110

www.ubstat.mn

www.1212.mn

ХОЛБОО БАРИХ

Хаяг: Нийслэлийн нутгийн
захиргааны байгууллагын "Б" барилга, 4 давхар
Арцатын ам,
Наадамчдын зам 1200

Утас: +(976)-11-328787
+(976)-11-327946
+(976)-11-322783
и-мэйл: ulaanbaatar@nso.mn